

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2016 оны 12-р сарын мониторингийн дүнгийн талаарх товч танилцуулга

Нээлттэй нийгэм форумаас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны сүүлээс эхлэн мониторинг хийж байна. 2017 оны эхний хагас жил хүртэл үргэлжлэх энэхүү мониторингийн хүрээнд уг хуулиар тодорхой хугацааны давтамжтайгаар нийтэд ил тод болгох мэдээллүүдээс зургааг нь сонгон авч 21 аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар(ЗДТГ)-ууд тэдгээрийг ил тод болгосон байдлыг ажиглаж байна.

2016 оны 12 дугаар сарын мониторингийн дүнгийн талаар товч дурдвал:

- **ЗДТГ-уудын цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнд холбогдох шийдвэрийн ил тод байдал хангалтгүй байна.** Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ тус бүрт холбогдох шийдвэр (хуулийн 6.10-р заалт)-ийг нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ууд 2016 оны 12 дугаар сард огт нийтлээгүй байна. Харин аймгуудын ЗДТГ-уудаас зөвхөн 5 нь буюу Орхон, Завхан, Дундговь, Сүхбаатар, Төв аймгуудын ЗДТГ цөөн тооны мэдээлэл нийтэлжээ.
- **Ихэнх ЗДТГ Төрийн санд бүртгэгдсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг бүрэн гүйцэд ил тод болгохгүй байна.** Энэ удаагийн мониторингоор 2016 оны 12 дугаар сард ЗДТГ-уудын ил болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн 2016 оны 12 дугаар сарын дансны хуулгатай харьцуулж үзэв. Энэхүү харьцуулалтаас харахад аймгуудын хувьд зөвхөн 7 аймгийн ЗДТГ Төрийн санд бүртгэгдсэн нийт гүйлгээнийхээ 50-иас дээш хувийг ил тод болгожээ. Тухайлбал, Өмнөговь, Орхон, Дундговь аймгуудын ил тод болгосон хувь харьцангуй өндөр байгаа бол Увс, Дархан-Уул аймгийн ЗДТГ Төрийн санд бүртгэгдсэн гүйлгээг огт нийтлээгүй байна. Нийслэл, дүүргүүдийн хувьд Багахангай, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдийн ЗДТГ-ын үзүүлэлт харьцангуй сайн буюу дунджаар нийт ил болгох мэдээллийн 96 хувийг, харин Улаанбаатар хотын ЗДТГ зөвхөн 21 хувийг ил болгожээ.